МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Нэг. Төлөвлөгөөний Нэгдүгээр бүлгийн 1.6 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:

1.6. Монгол Улсын “Цахилгаан холбооны сүлжээний дугаарлалтын формат, түүнд тавих ерөнхий шаардлага” стандарт, Олон улсын цахилгаан холбооны байгууллагын ITU-T E.164, ITU-T E.212 болон холбогдох зөвлөмжийг мөрдлөг болгоно.

Хоёр. Төлөвлөгөөний Нэгдүгээр бүлэгт дараах агуулгатай 1.9 дэх заалт нэмэх:

1.9. Харилцаа холбооны дугаарлалт, сүлжээний таних кодын нөөцийг зориулалт, техникийн функцээр нь дараах байдлаар ангилна.Үүнд:
1.9.1. ITU-T E.164-д хамаарах нийтийн цахилгаан холбооны дугаарлалтын нөөц;
1.9.2. ITU-T E.212-т хамаарах хөдөлгөөнт холбооны сүлжээ, захиалгыг таних кодын нөөц.

Гурав. Төлөвлөгөөнд дараах агуулгатай “Дөрөвдүгээр бүлэг” нэмэх:

ДӨРӨВ. ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ЗАХИАЛГЫН ТАНИХ КОДЫН ТӨЛӨВЛӨЛТ

4.1. Монгол Улсад хуваарилагдсан хөдөлгөөнт холбооны улсын код (Mobile Country Code, MCC) нь 428 байна.
4.2. Хөдөлгөөнт холбооны сүлжээний код (Mobile Network Code, MNC) нь MCC-ийн хүрээнд хөдөлгөөнт холбооны сүлжээг ялган таних хоёр эсхүл гурван оронтой код байна. Монгол Улсын MCC 428-ийн хүрээнд MNC-г хоёр оронтойгоор төлөвлөнө.
4.3. Нийтийн хөдөлгөөнт холбооны сүлжээний таних код (Public Land Mobile Network Identifier, PLMN ID) нь MCC болон MNC-ээс бүрдэх бөгөөд хөдөлгөөнт холбооны сүлжээг ялган танихад ашиглагдана.
4.4. Хөдөлгөөнт холбооны олон улсын захиалгын таних дугаар (International Mobile Subscription Identity, IMSI) нь MCC, MNC болон захиалгыг таних дугаараас бүрдэх бөгөөд ITU-T E.212 зөвлөмжийн дагуу төлөвлөгдөнө.
4.5. MNC-ийн нөөцийг нийтийн хөдөлгөөнт холбооны сүлжээ, хөдөлгөөнт виртуал сүлжээ, хиймэл дагуулын болон газрын бус сүлжээ, тусгай зориулалтын хөдөлгөөнт сүлжээ, туршилт, судалгаа болон ирээдүйн хэрэгцээнд зориулан төлөвлөнө.
4.6. MNC-ийн нөөцийг төлөвлөхдөө одоо ашиглаж байгаа кодын хуваарилалт, нөөцийн хүрэлцээ, техникийн нийцэл, шинэ технологи, үйлчилгээний хэрэгцээ болон нөөцийн үр ашигтай ашиглалтыг харгалзан үзнэ.
4.7. MNC-ийн хуваарилалт, ашиглалт, бүртгэл, хяналт, буцаан таталт болон IMSI-ийн удирдлагатай холбоотой нарийвчилсан харилцааг Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлагдсан журмаар зохицуулна.

Дөрөв. Төлөвлөгөөний Хавсралт 2-т дараах нэр томьёог нэмэх:

Хөдөлгөөнт холбооны улсын код (MCC) — ITU-T E.212 зөвлөмжийн дагуу улс, газар зүйн бүсийг ялган таних гурван оронтой код.
Хөдөлгөөнт холбооны сүлжээний код (MNC) — MCC-ийн хүрээнд хөдөлгөөнт холбооны сүлжээг ялган таних хоёр эсхүл гурван оронтой код.
Нийтийн хөдөлгөөнт холбооны сүлжээний таних код (PLMN ID) — MCC болон MNC-ээс бүрдэх хөдөлгөөнт холбооны сүлжээний таних код.
Хөдөлгөөнт холбооны олон улсын захиалгын таних дугаар (IMSI) — MCC, MNC болон захиалгыг таних дугаараас бүрдэх, хөдөлгөөнт холбооны захиалгыг ялган таних дугаар.